



ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/10

Өмнөдэлгэр сум

Өмч хамгаалах байнгын зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 04 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Ү.Оюунчимэг Дүн бүртгэгч

Гишүүд: Б.Алтанцэцэг Сувилагч

Б.Сэр-Од Нягтлан бодогч

О.Наранхүү Сантехникч

2. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журмыг баримтлан, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган, идэвх санаачлагатай ажиллахыг зөвлөлийн дарга (Ү.Оюунчимэг)-д даалгасугай.

3. Эрүүл мэндийн төвийн даргын 2024 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн А/26 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Ц.АРИУНТУНГАЛАГ

My document /alban bichig A4/ Tushaal2026

